



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

### Судалгаа хийлгэх тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн 2.1.15, Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай нийслэлийн Засаг даргын 2015 оны А/198 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.3, 3.2.4, 4.5, дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Нийслэлийн нийгэм, соёлд үзүүлж буй аялал жуулчлалын нөлөөлөл” судалгааны ажлыг гүйцэтгэх бага үнийн санал ирүүлсэн Эс Ай Си Эй ХХК-тай гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Гэрээт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, судалгааны тайланг 2015 оны 07 дугаар сарын 20-ны дотор хүлээн авч танилцуулахыг Статистик, судалгаа хариуцсан мэргэжилтэн /Б.Жаргалан/-д үүрэг болгосугай.

3. Судалгааны ажлын зардал болох 7.970.050 /Долоон сая есөн зуун далан мянга тавин/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА